



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/127

Жаргалант

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.1.6 дахь заалт, Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний 13 дугаар хуралдааны дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулж орон байраар хангах зорилгоор шинэ залуу төрийн албан хаагч, багш, эмч нарын амьдрах хуучин цэцэрлэгийн байрны 7 өрөөний сарын ашиглалтын гэрээний төлбөрийг 100000 (нэг зуун мянга) төгрөгөөр тогтоож дэмжлэг үзүүлсүгэй.

2.Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хуучин цэцэрлэгийн байрны 2 өрөөг буудлын зориулалтаар, 1 өрөөг цайны газрын зориулалтаар ашиглуулсугай.

3.Төрийн албан хаагчидтай ашиглалтын гэрээг байгуулж төлбөрийг хугацаанд барагдуулж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ